

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойсүрэн	Дугаар	L007
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Зуунмод
Төрсөн газар	Төв аймаг	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сүнгийн аймаг, Дашчоймбэл дацан	Сүм хийдийн дугаар	UBR 912
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Их хүрээний Сүнгийн аймаг, Дашчоймбэл дацан

Чойсүрэн- 1916 онд төрсөн. 8 наснаас 16 нас хүртэл Сүнгийн аймаг, Дашчоймбэл дацанд хүрж байсан. Манай аав, ээжийн таньдаг лам Ганданд байсан. Намайг найман настай байхад тэндээ хүргэж өгөөд би 19 хүртлээ ламынд тогоо бариад л ном үзээд л байж байсан аж. Манай багш бол Дашчоймбэл дацангийн шунлайв Вандан шунлайв гэдэг хүн байсан юм. 19 хүрээд намайг Дашчоймбэл дацанд оруулаад 20, 21 гээд 3 жил хураад манай багшийг бариад явсан. Би хашаандаа ганцаараа бас манай багшийн бас нэг шавь 5 ханатай том гэртэй залуухан лам байсан. Би 4 ханатай жижигхэн гэрт багштайгаа хоёулхнаа байдаг. Хоол цайг нь хийгээд өгчихнө. Жаахан сүүтэй цай чанаад өгчихнө. Өөрөө бол хар цай уучихна. Манай багшийг өвөл нь бариад явчихсан. Би тэндээ өвөлжөөд байтал хавар нь манай эцэг дуулчихаад эмээлтэй морь барьж ирээд аваад

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

явсан. Тэгээд хөдөө адуу мал маллаж байсан. 25 хүрээд цэрэгт яваад тэр үед Халх голын байлдаан болсон. Японтой байлдаад Япон ялагдаад дайн дууслаа. Тэгээд Матад суманд ирээд 8-р дивизэд хугацаагаа дуусгасан. Маршал Чойбалсан цэргийн хугацаа 3 байсныг 5 жил болгоод би 5 жил явсан. Халагдаж ирээд хөдөө Баянцагаанд байсан. Авгай хүүхэд аваад малаа нэгдэлд нийгэмчлээд ах дүү, төрөл садан минь ажил төрөл хөөгөөд аймаг хот руу ирчихээр би ганцаараа Баянцагаанд байж яахав гэж бодоод Сэргэлэнд малаа тууж ирээд нийгэмчилж өгөөд нэгдлийн гишүүн болсон. Сэргэлэн суманд үхэр тэргийг нь хөтөлж ч явлаа, манааг нь манаж ч явлаа, Богд ууланд мод хөрөөдөөд түлээ модыг нь бэлдэж ч байлаа. Албан газар ажил хийгээгүй. Дандаа нэгдлийн ажил хийж байлаа. Тэгээд энэ хурал нээгдэхээр багадаа 8 наснаасаа 19 хүртэл үзэж байсан номоо үзсэн чинь “Дэг дуг” гээд бас сайнгүй л байна. Энэ хурал нээгдээд 18,19 жил болж байна. 1991 оны 6 сард нээгдсэн байх. Одоо 8,15,29, битүүн гээд 4 хуралд очдог бусдад нь очиж чаддаггүй.

Дашчоймбэл дацан их олон лам нартай. 19 наснаас эхлээд 3 жил Дашчоймбэлд хурсан. Намайг хурж байхад Дашчоймбэл их олон ламтай байсан. Гол шүтээн нь Гомбо сахиус байсан. Миний цуг байж байсан лам баригдаад 5 жил баригдаад 4 жил болоод гараад ирсэн. Баянцагаанд намайг байж байхад багшийг суллагдаад гарч ирснийг мэдээд эмээлтэй морь хөтөлж ирээд багшийгаа хөдөө аваачсан. Багш маань Дэлгэр Өлзийтийн жас дээр байж байгаад таалал төгссөн. Дэлгэр-Өлзийтийн жас гэдэг чинь Баянцагаан сумаас баруун тийш жаахан хийдийн байшин сав амьтан юм хумаа хадгалдаг тийм газар болчихсон байсан юм. Тэгээд манай багш тэнд байж байгаад таалал төгссөн.

Хадаг, Шидүв, Жумбарай гээд 3 жил сураад 4 дэхь жил дээрээ хөдөө гарсан. Манай багш Дашчоймбэл дацангийн хамба байсан. Вандан шунлайв гэдэг хүн байсан юм. Хамгийн том лам нь байсан. Манай багш бүр урагшаа говийн Мэргэн вангийн нутгийн хүн гэнэ лээ. Хүрээнд жаахнаасаа ном үзэж байгаад Дашчоймбэлийн хамба болсон. 80 хэдэн насандаа таалал төгссөн. Манай багш их сайхан хүн байсан, аашилж загнахгүй. Би бол гарынх нь сүүлчийн лам байсан. Би уншлага гүйцээчихсэн, багшаараа Чойр заалгаж байсан. Орчуулга бас заалгаж байсан.

Би Дашчоймбэл дацанд хурахаасаа өмнө Сүнгийн аймагт хурж байсан. Сүнгийн аймагт олон жил хурсан. Сүнгийн аймаг нэг их олон ламгүй байсан. Сүнгийн аймгийн хамба нь Гэндэнжав, Чимиддорж гэдэг хүн байсан. Дэмбэрэл гэж гэсгүй байсан. Сундуйрэгзэн гэж унзад нь байсан.

Сүнгийн аймаг Лхам сахиустай байсан. Дашчоймбэл Гомбо сахиустай. Өдөр болгон хурал хурдаг Цогчэн уншлага хурдаг. Уншдаг жасаа ном гэж Найдан, Гавсүм, Дэмбэрэлдовд гэдэг ном байсан юм. Дашчийравын гэдэг сан уншаад магтаалуудыг уншаад хориод ном уншдаг байсан. Хурал хурдаг дуганатай тэрний хажууд жижиг модон гэр байх. Тэр гэрт 1 хүн байдаг тэр хаалга үүд цоожилж бариад л байдаг байсан.

Дашчоймбэлд Чойрыг л их хэлэлцэж, хаялцдаг байсан. Хадаг, шидүв, жумбарай, юүлжин, дондонжу, ог, гом, дом гээд 8 жил сурна. Зиндаа тус бүр 8 жил сураад дом хураад гавж болно. Гавж, аграмба гээд дээшээ явна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Би аймгийн дацанд 10 гаруй жил хурчихаад дацанд хурах юмсан гэж боддог байсан. Манай багш бага байна гээд л байсан. Өглөө нь хуралдаа хурна. Тэгээд гэртээ ирээд номоо уншаад тогоо шанагаа бариад багшийгаа өргөж тойлдог байлаа. Тэгсэн намайг 19 хүрэхэд хүүгээ Дашчоймбэлийн босго алхуулъя гэж хэлээд оруулсан юм.

Хүрээнд 30 аймаг байсан. Дашчоймбэл, Гунгаачоймбэл, Игдаачойнзонлин гэж 3 дацан байсан. Дашчоймбэлд хайлан хурна.

Гандангийн дэнжид гаднаас эмэгтэй хүн ордоггүй байсан. Эцэг эх хоёр минь намайг эргэх гээд ирнэ. Аав гэрт ороод ирнэ. Гудамжны адагт нэг хүрд байна. Ээж тэрний тэнд сууж байна. Би нэг данхтай халуун цай, жаахан боовтой аваачиж өгнө. Хүрдний тэнд сууж байгаад цай ууж боов идчихээд надтай тэндээ уулзчихаад явдаг байсан. Манай зиндаанд 20 гаруй л лам байсан байх. Зиндааны анги нь Сандуйжав гэдэг хүн байсан.

Дашчоймбэлд жилдээ 4 удаа нэг удаад нэгд нь 4 лам гавжийн дамжаа барина. Жилд 16 орчим лам гавж болдог байсан байх гэж бодож байна. Нэг хүн хоёр хоёр өдрөөр юм уу, гурав гурван өдрөөр барьдаг байсан. Дамжаа барьж дууссаны дараа дайллага цайллага болно доо.

Одоо Бурхны шашин Монголд улам илүү хөгжихөд Чойрын номоо сайн үзэж, номынхоо мөн чанарыг сайн танин мэдэж судлаасай гэж хүсдэг дээ.